



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/94

Биндэр сум

**Монгол улсын иргэнд
газар өмчлүүлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.15 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XXI.1.57 –д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтад дурдсан 1 иргэнд 1443 м2 газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсүгэй.

2. Захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2014 оны А/56 тоот захирамжийн холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

3. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Н.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН



Биндэр сумын Засаг даргын 2026 оны 06 дугаар сарын 04 өдрийн А/56 дугаар захирамжийн хавсралт



№	Газар өмчлөгчийн				Өмнөх захирамжийн			
	Ургийн овог	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Огноо	Дугаар	Хавсралтын дугаар	Холбогдох хэсгийн дугаар
1	Сартуулхайдал	Гүррагчаа	Цэрэнбалт	СЖ09291309	2014.06.24	A/56	1	43

№	Өмнөх газрын			Одоо		
	Нэгж талбарын дугаар	Хэмжээ /м2/	Хаяг	Нэгж талбарын дугаар	Хэмжээ /м2/	Хаяг
1	2310002465	1600	Нуур	2310002465	1443	Нуур-2, 200а
					1443 м2	